



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Зарим аймаг, дүүрэгт хуулийн хэрэгжилттэй танилцсан дүнгийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Байнгын хорооноос байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд зарим аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцсан дүнг хэлэлцээд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлэх, Засаг даргыг томилох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдаас гаргасан саналуудыг холбогдох хуулийн төсөлд тусгах асуудлыг судлан үзэхийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах, Сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл, Улс төрийн намын тухай болон Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч /Л.Цог, Р.Бурмаа, С.Баярцогт/-д үүрэг болгосугай.

2.Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгох нь:

1/Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1-д “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн хараат бус байдал, иргэдийн оролцоог хангах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

2/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

3/Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах ажлыг удирдан зохион байгуулахад баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын үүрэг нэмэгдэж байгааг харгалзан иргэдийн нийтийн Хурлыг ажиллах нөхцөлөөр хангах, шинээр сонгогдож, томилогдсон баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын дарга, тэргүүлэгчид, баг, хорооны Засаг дарга нарыг төлөвлөгөөтэйгээр сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;


4/Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5-д заасныг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг

авах;

3.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг сурталчлах, өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх үед холбогдох салбарын мэргэжилтэн, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авах ажлыг Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвүүдээр зохион байгуулах, тус төвийн эрх зүйн байдал, чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авахыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Б.Болдбаатар/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгийн талаар Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд, Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Нутгийн удирдлагын дэд хороо /Д.Батцогт/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ